

“ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА” БҮЛЭГ СЭДВИЙН ДҮГНЭЛТ

D.Urantsetseg@must.edu.mn

1.Тоогоор дугаарласан нэр томъёог үсгээр тэмдэглэсэн тохирох утга санаа, тодорхойлолтуудтай зөв тохируулна уу.

■ **Олон улсын харилцаа, түүний хэлбэр хандлага:**

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Олон улсын харилцаа | а | Хамтын ажиллагаа, өрсөлдөөн,хараат байдал, дайтах зэрэг |
| 2 | Олон улсын харилцааны хэлбэрүүд | б | Дэлхийн бодлого туйлуудаас хамаарах, даяаршил, бүс нутаг, салбар бүс нутгийн интеграцлал, мэдээллийн технологийн хүчин зүйл, дэлхий дахиныг нийтэд нь хамарсан глобаль (тулгамдсан) асуудлууд зэрэг |
| 3 | Орчин үеийн олон улсын харилцааны хандлагыг тодорхойлогч хүчин зүйл | в | Дэлхийн олон нийтийн бие даасан гишүүн болсон эрхийн субъектуудын хоорондын харилцаа |

2. Дэлхийн бодлого туйлуудаас хамаарах нь:

| | | | |
|---|--------------|---|---|
| 1 | Нэг туйлт | а | Гол дүрэм нь: (1) Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжлох (2) Нөгөө хоёр талын хооронд ойр дотны хамтын ажиллагаа бий болохоос сэргийлэх явдал байдаг. |
| 2 | Хоёр туйлт | б | Тоглоомын дүрэм нь: (1) Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцэх (2) Хүчээ аль болох ихэсгэх, хадгалах. (3) Аль нэг талтай дайтсан ч системийг бүхэлд нь тогтворжуулах хэрэггүй. |
| 3 | Гурван туйлт | в | Гол онцлог нь хоёр туйлийн хооронд дайсагнасан өрсөлдөөн байдаг. Үндсэн дүрэм нь: (1) Нөгөө эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролддог. (2) Өөрийн хүчийг байнга нэмэгдүүлэхийг оролддог. Нөгөө эвслийн гишүүнийг өөртөө татах, өөрөөсөө гишүүнээ алдахгүй байх гэх мэт тактик ашиглана. |
| 4 | Олон туйлт | г | Тоглоомын дүрэм: (1) Цөм их гүрэн нь үндсэн зарчмыг тогтоон хэрэгжүүлж, цэрэг эдийн засгийн хувьд ноёрхоно. (2) Өөрийн нөлөөнд буй нэгжүүдийн хоорондын зөрчилдөөнийг зохицуулна. (3) Нэгж улсуудын тусгаарлах, бие даах оролдлогыг таслан зогсооно. |

СОНГОХ ТЕСТ. Зөв хариултыг сонгоно уу.

3. Төрийн гадаад бодлогын хэрэгсэлд илүүц зүйл бичсэн бол аль нь вэ?

А.Мэдээлэл, суртал нэвтрүүлгийн Б.Улс төрийн В. Эдийн засгийн

Г. Эрх зүйн Д. Цэргийн

4.БНМАУ нь ЗХУ-тай гадаад худалдааныхаа 97 хувийг хийдэг төдийгүй, олон улсын байгууллагад элсэх, улсуудтай дипломат хамтын ажиллагаа тогтоох зэрэгт зөвлөлтөөс зөвшөөрөл авдаг байжээ. Энэ нь олон улсын харилцааны аль хэлбэрт хамаарагдаж байна вэ?

А. Хамтын ажиллагаа Б. Хараат байдал В. Өрсөлдөөн Г. Дайны байдал

5. Азийн хувьд дэлхийн бодлогод хүчтэй нөлөөлөгч Хятад , Энэтхэг ,Япон зэрэг улсууд Европод Франц , Герман улсууд АНУ-ын хэт давамгайллыг тогтоон барихыг сонирхож байгаа. Мөн Орос улс ч дэлхийн бодлогод үзүүлэх нөлөөллөө өргөтгөх зорилгоор Хятад , Энэтхэг улсуудтай стратегийн түншлэлээ өргөжүүлэхийг чармайж байгаа гэж судлаачид үзэж байна. Ийм тохиолдол бодит байдал болоход дэлхийн бодлого хэдэн туйлаас хамаарч байна вэ?

А. Нэг туйл Б. Хоёр туйл В. Гурван туйл Г. Олон туйл

6. Евролын холбоо , АПЕК, АСЕМ, АСЕАН, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхтэй ажиллаж байгаа нь орчин үеийн олон улсын харилцааны аль хандлага вэ?

- А. Бүс нутгийн интеграцлал Б. Даяаршил В. Туйлуудаас хамаарах
Г. Мэдээллийн технологийн хүчин чадал

7. Олон улсын терроризм өнөөгийн дэлхий дахинаа нүүрлэж буй хамгийн том аюулын нэг болжээ. 2001 оны 9 сарын 11-ний үйл явдал нь аюулгүй байдлын тухай уламжлалт ойлголт , төсөөллийг өөрчилж , терроризмын аюулын өмнө хүн төрөлхтөн улам бүр эмзэг ,өртөмтгий болж байгааг харуулсан юм. Энэ нь олон улсын харилцааны хандлагын -----д хамааралтай асуудал вэ?

- А. Бүс нутгийн интеграци Б. Даяаршил
В. Туйлуудаас хамаарах Г. Глобаль асуудал

Нөхөх тест. Орхигдсон үгийг нөхнө үү.

8. Төрийн гадаад бодлогын үүргүүд нь

- А.Батлан хамгаалах Б. ----- В.-----

9.Олон улсын хүний эрхийг хамгаалах тогтолцоог тайлбарлана уу?

А. НҮБ, Европын холбоо

В. НҮБ, Европын холбооны баталсан гэрээ

С. Олон улсын шүүх,хяналт тавих тусгай горимын цогц

Д.Дээрх бүгд зөв

10.Хүүхдийн эрхийн зарчмуудыг нэрлэнэ үү?

А. Алагчлахгүй байх

Б. Ашиг сонирхлыг эрхэмлэх

В. Эрхийг нь бүрэн эдлүүлэх

Г. Дээрх бүгд зөв

11. Хүний эрхийн гэрээнд нэгдэх үе шатуудыг гүйцээж бичнэ үү?

А. Гарын үсэг зурах

Б. Соёрхон батлах

В. -----

12. Хүний эрхийн хэрэгжилтэнд хэрхэн хяналт тавих вэ?

А. Тайлагнах

Б.Судлах

В.Гомдол гаргах

Г. АВ зөв

13.Гэм буруутан гэж хэн бэ?

А. Хууль бус үйлдэл хийсэн , бусдад хохирол учруулагч этгээд

Б. Гэм буруутай этгээд

В. Хууль бус үйлдэл хийсэн этгээд

ХАРИУЛТ

| | | | | | | | | | |
|------------|--------------|---|---|---|---|---|--|---|----|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1B2A3 Б | 1B2B3A4 Г | A | Б | Г | A | В | 2.Дэлхийн бусад орнуудтай энх тайвнаар зэрэгцэн оршино. 3.Олон улсын гэрээ хэлэлцээрийг даган биелүүлнэ | D | Г |

| | | | | | | | | | |
|-----------------|----|----|---------------------|----|----|----|----|----|----|
| 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 |
| Тайлбар хийх | Г | A | Урьдчилан сэргийлэх | Б | Г | В | A | A | Б |